# Оршил хуудаснууд

Өөр өөр төмөр ялтсан ном дээр өөр өөрсдийн үгийг цэдэглэсэн эртний бошиглогчид Мормоны Номыг бичсэн. Тэрхүү цэдгүүдийг Иосеф Смитийн орчуулсан, Мормоны буюу алтан ялтаснуудыг бүтээхийн тулд хожим нь эмхэтгэжээ.

**Ярилцлага**

Алтан ялтаснууд дээр цэдэглэгдэж болох байсан зүйлстэй харьцуулбал, Мормон болон бусад бошиглогч Мормоны Номд зориулан зөвхөн багахан хэсгийг сүнсний удирдамжийн дагуу сонгожээ (Мормоны үгс 1:5 болон 3 Нифай 26:6). Үүнийг мэдэх нь өнөөгийн бидэнд байгаа бүлгүүдийн талаарх таны бодолд хэрхэн нөлөөлөх вэ? ■

# Мормоны Номыг аль ялтаснуудыг нийлүүлж бүтээсэн бэ?

Бошиглогч Иосеф Смитэд өгсөн Мормоны ялтаснууд



Мормоны ялтаснуудын зарим эх сурвалж

**Нифайн бага ялтаснууд**
(МЭӨ 600–МЭӨ 130*):
1 Нифай, 2 Нифай, Иаков, Инос, Жером, Омнай

**Нифайн их ялтаснууд**
(МЭӨ 600 –МЭ 385):
Лихай, Мозая, Алма, Хиламан, 3 Нифай, 4 Нифай, Мормон 1–7

**Иферийн ялтаснууд**
(барагцаалахад МЭӨ 2300–МЭӨ 130 он хүртэл)

**Гуулин ялтаснууд**
(МЭӨ 4000 –МЭӨ 600):
Эдгээр ялтсан дээрх олон эшлэл Мормоны Номд байдаг.

* Онууд нь ялтас бүрийн хамарсан ойролцоо цаг хугацааг зааж байгаа.

Мормоны ялтаснууд:

**Лихайн ном**
(Мормоны эмхэтгэсэн хэсэг, Мартин Харрисын алдсан 116 хуудас)

**1 Нифай–Омнай**
(эмхэтгээгүй; Нифайн бага ялтаснуудаас авсан)

**Мормоны үгс** ← Нифайн бага ялтаснуудыг оруулсан талаарх Мормоны тайлбар

**Мозая–Мормон 7**
(Мормоны эмхэтгэсэн, Нифайн их ялтаснууд)

**Мормон 8–9** ← Моронайн эцгийнхээ номыг дуусгаж бичсэн хэсэг

**Ифер** (Моронайн эмхэтгэсэн Иферийн ялтаснууд)

**Моронай** ← Нүүр хуудсыг багтаасан Моронайн бичээсүүд

**Лацдагдсан хэсэг**



ИОСЕФ СМИТИЙН БОЛОН ТЭНГЭР ЭЛЧ МОРОНАЙН ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙАН БИЙЧ

1
дэх долоо хоног